



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/231

Улаанбаатар хот

Цалинтай чөлөө олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.10, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5, 39 дүгээр зүйлийн 39.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын хэмжээнд боловсролын байгууллагын багш, ажилчид цалин хөлсөө нэмэгдүүлэх хөдөлгөөн өрнүүлж хугацаагүй ажил хаялт зарласантай холбогдуулан хүүхдийн аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын 12 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч нарын аль нэгийг цахимаар ажиллуулах эсхүл ажлын цагийг байгууллагын онцлог, дотоод зохион байгуулалттай уялдуулан 09:00-12:00, 14:00-17:00 цаг байхаар зохицуулж 2 цагийн цалинтай чөлөөг олгосугай.

2.Тус шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллахыг дүүргийн аж ахуйн нэгж, албан байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД